



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/343/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ай Жэй Эй Эйч аудит ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас: 99040059 Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.Хараат бус аудиторын дүгнэлт | 2 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 10 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 11 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт..... | 12 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл | 12 |
| 3.5.3 Нэмэлт төсөв | 13 |
| 4. Аудитын тайлан | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 14 |
| 4.2 Материаллаг байдал..... | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 14 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 15 |
| 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн..... | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. Аудитын илрүүлэлт | 16 |
| 5.1 Зөвлөмж | 16 |
| 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАГЧИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ГАНБАТ ТАНАА

2023 02 20 № 07/329
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг цахимд шилжүүлж e-mongolia системтэй холбож, газар эзэмшүүлэх ажлыг хөнгөвчлөн ажиллаж байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 10,751,698.0 мянган төгрөгийн хөрөнгийг Хил хамгаалах Ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэх асуудлыг холбогдох газруудад танилцуулж, шийдвэрлээгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн төсөлд үйл ажиллагааны орлого /газар эзэмшүүлэх, ашиглуулах/ нийт 6,970,000.0 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөгөө батлагдсан боловч зарим тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн зохицуулалт хийснээс шалтгаалан 6,486,927.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжгүй болж, 483,072.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН,
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М.* Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-----------|--|--------------------------|--------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 59,071,508.00 | 18,623,120.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | | |
| 33 | АВЛАГА | 47,999,630.00 | 386,260.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 47,999,630.00 | 386,260.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 11,071,878.00 | 18,236,860.00 |
| 354 | Хангамжийн материал | 11,071,878.00 | 18,236,860.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,639,529.00 | 4,039,684.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 1,936,000.0 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,769,000.00 | 5,516,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 261,250.00 | 90,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,402,099.00 | 6,654,026.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 38,443,031,028.73 | 35,807,717,071.87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 38,443,031,028.73 | 35,807,717,071.87 |
| 392 | Биет хөрөнгө | 37,361,934,476.54 | 34,804,706,091.20 |
| 39201 | Барилга, байгууламж | 740,076,622.20 | 805,576,622.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (63,435,139.20) | (85,535,393.91) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 82,814,635.16 | 34,847,635.16 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (69,897,968.45) | (34,847,635.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 155,277,906.90 | 155,277,906.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (87,250,430.37) | (107,433,169.81) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 25,898,779.80 | 25,898,779.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (17,058,388.59) | (17,977,431.03) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 31,655,582,315.24 | 31,655,582,315.24 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,811,771,909.15) | (8,378,381,591.19) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 10,751,698,053.00 | 10,751,698,053.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,081,096,552.19 | 1,003,010,980.67 |
| 39301 | Программ хангамж | 1,705,000.00 | 1,705,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (281,111.16) | (849,444.60) |
| 39303+393 | Бусад биет бус хөрөнгө | 1,804,306,857.00 | 1,804,306,857.00 |
| 39304+393 | Хуримтлагдсан элэгдэл | (724,634,193.65) | (802,151,431.73) |
| 3 | НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН | 38,502,102,536.73 | 35,826,340,191.87 |
| 4 | НИИТ ӨР ТӨЛБӨР | 48,655,880.00 | 131,250.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 48,655,880.00 | 131,250.00 |
| 413 | Өглөг | 47,999,630.00 | - |
| 41361 | Байгууллага төлөх өглөг | 47,999,630.00 | - |
| 414 | Урьдчилж орсон орлого | 656,250.00 | 131,250.00 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 656,250.00 | 131,250.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 38,453,446,656.73 | 35,826,208,941.87 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 38,453,446,656.73 | 35,826,208,941.87 |
| | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ | 1,350,902,876.02 | 1,350,902,876.02 |
| 51101 | Өмч:-Төрийн өмч | 1,350,902,876.02 | 1,350,902,876.02 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 37,090,968,399.56 | 34,463,730,648.70 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 37,090,968,399.56 | 37,090,968,399.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (2,627,237,714.86) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,575,381.15 | 11,575,381.15 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 38,502,102,536.73 | 35,826,340,191.87 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|--------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 10,234,920,188.00 | 1,049,328,443.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 81,242,263.00 | 549,097,643.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 81,242,263.00 | 549,097,643.00 |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 80,770,105.00 | 548,572,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,479,650.00 | 483,072,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 66,290,455.00 | 65,500,000.00 |
| 120009 | Бусад орлого | 472,158.00 | 525,143.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,153,677,925.00 | 500,230,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,554,169,555.00 | 465,653,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 802,469,600.00 | 465,653,300.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 7,751,699,955.00 | |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,599,508,370.00 | 34,577,500.00 |
| ДТ(131104) | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөв | 1,460,584,370.00 | |
| ДТ(131105) | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 138,924,000.00 | 34,577,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 5,072,709,751.32 | 3,667,816,157.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,072,709,751.32 | 3,667,816,157.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,964,102,553.70 | 3,426,084,708.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 468,471,665.74 | 412,630,539.38 |
| 210101 | Үндсэн цалин | 375,469,524.26 | 310,763,017.13 |
| 210102 | Нэмэгдэл | 55,920,988.68 | 42,534,201.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,116,716.55 | 43,969,478.32 |
| 210104 | Урамшуулал | 9,964,436.25 | 15,363,842.64 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 60,707,194.82 | 52,287,665.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,652,590.79 | 35,795,404.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,836,974.59 | 4,211,224.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,266,219.49 | 3,305,139.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 541,037.40 | 815,990.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,410,372.55 | 8,159,906.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 120,326,445.15 | 106,628,988.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 85,040,965.00 | 79,139,269.55 |
| 210302 | Түлш, халаалт | 6,300,000.00 | 4,551,139.35 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,985,480.15 | 22,938,579.53 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,183,780.66 | 15,778,311.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,361,294.88 | 4,108,185.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 5,739,000.00 | 1,840,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,026,562.78 | 5,283,693.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,056,923.00 | 4,198,073.00 |
| 210408 | Бараа материалын акталсны зардал | | 348,360.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 36,144,900.00 | 18,725,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 239,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 35,905,900.00 | 18,725,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,918,255.00 | 8,339,261.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,918,255.00 | 8,339,261.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 105,710,062.01 | 119,136,936.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 94,262,850.00 | 114,750,180.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 5,980,000.00 | 2,020,000.00 |
| 210803 | Даатгалыг үйлчилгээний төлбөр | 525,690.00 | 427,680.00 |

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|-------------------------|---------------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 613,139.00 | 577,256.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,957,227.01 | 978,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 305,156.00 | 383,520.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,136,640,250.32 | 2,692,557,156.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,460,584,370.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 496,800.00 | 493,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,675,559,080.32 | 2,692,063,956.75 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 108,607,197.62 | 241,731,448.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,163,700.00 | 700,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,491,700.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 672,000.00 | 700,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 91,443,497.62 | 241,031,448.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 77,452,897.62 | 241,031,448.76 |
| 213304 | Хөрөнгийн | 13,990,600.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 5,162,210,436.68 | (2,618,487,714.75) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 8,750,000.11 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 8,750,000.11 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | | (8,750,000.11) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН | 5,162,210,436.68 | (2,627,237,714.86) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|--|--------------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 10,168,235,983.00 | 983,303,443.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,558,058.00 | 483,072,643.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,558,058.00 | 483,072,643.00 |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,479,650.00 | 483,072,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,479,650.00 | 483,072,500.00 |
| 120009 | Бусад орлого | 78,408.00 | 143.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,153,677,925.00 | 500,230,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,554,169,555.00 | 465,653,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 802,469,600.00 | 465,653,300.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 7,751,699,955.00 | |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,599,508,370.00 | 34,577,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | 1,460,584,370.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 138,924,000.00 | 34,577,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,430,526,628.00 | 983,303,443.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,430,526,628.00 | 983,303,443.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,321,919,430.38 | 741,571,994.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 468,665,834.17 | 412,630,539.38 |
| 210101 | Үндсэн цалин | 376,584,647.50 | 310,763,017.13 |
| 210102 | Нэмэгдэл | 55,000,033.87 | 42,534,201.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,116,716.55 | 43,969,478.32 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 9,964,436.25 | 15,363,842.64 |
| 2102 | Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл | 60,513,026.39 | 52,287,665.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,652,590.79 | 35,795,404.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,836,974.59 | 4,211,224.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,266,219.49 | 3,305,139.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 541,037.40 | 815,990.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,216,204.12 | 8,159,906.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 120,326,445.15 | 106,628,988.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 85,040,965.00 | 79,139,269.55 |
| 210302 | Түлш, халаалт | 6,300,000.00 | 4,551,139.35 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,985,480.15 | 22,938,579.53 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,540,871.41 | 20,713,043.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,183,904.88 | 5,634,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,508,000.00 | 5,587,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,012,190.53 | 5,669,953.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,836,776.00 | 3,821,590.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 42,489,850.00 | 18,725,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,704,350.00 | |
| 210602 | Тавилга | 1,879,600.00 | |
| 210604 | Урсгал засвар | 35,905,900.00 | 18,725,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,918,255.00 | 8,339,261.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 12,918,255.00 | 8,339,261.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 129,383,978.26 | 121,753,446.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 116,018,022.25 | 117,231,310.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,980,000.00 | 2,020,000.00 |

**Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | |
|--------|---|---------------------------|----------------|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 525,690.00 | 427,680.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 613,139.00 | 577,256.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,662,227.01 | 978,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 518,900.00 | 518,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,461,081,170.00 | 493,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,460,584,370.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 496,800.00 | 493,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 108,607,197.62 | 241,731,448.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,163,700.00 | 700,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,491,700.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 672,000.00 | 700,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 91,443,497.62 | 241,031,448.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 77,452,897.62 | 241,031,448.76 |
| 213304 | Хөрөнгийн | 13,990,600.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 7,737,709,355.00 | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 7,751,699,955.00 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,751,699,955.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 7,751,699,955.00 | |
| 220001 | Барилга байгууламж | 7,751,699,955.00 | |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (7,751,699,955.00) | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (13,990,600.00) | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 13,990,600.00 | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|--------------------------|--|
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,350,902,876.02 | 11,575,381.15 | 31,928,767,127.88 | 33,291,245,385.05 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 5,162,201,271.68 | 5,162,201,271.68 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,350,902,876.02 | 11,575,381.15 | 37,090,968,399.56 | 38,453,446,656.73 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,350,902,876.02 | 11,575,381.15 | 37,090,968,399.56 | 38,453,446,656.73 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | (2,627,237,714.86) | (2,627,237,714.86) |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,350,902,876.02 | 11,575,381.15 | 34,463,730,684.70 | 35,826,208,941.87 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-------------------------|-----------------------|-------------------------|-------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,859,653,300.00 | 717,331,858.41 | 1,142,321,441.59 | 38.6 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,859,653,300.00 | 717,331,858.41 | 1,142,321,441.59 | 38.6 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,858,308,500.00 | 716,631,858.41 | 1,141,676,641.59 | 38.6 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 456,976,400.00 | 409,403,480.87 | 47,572,919.13 | 89.6 |
| Үндсэн цалин | 364,997,700.00 | 308,547,358.62 | 56,450,341.38 | 84.5 |
| Нэмэгдэл | 61,974,600.00 | 42,534,201.29 | 19,440,398.71 | 68.6 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 30,004,100.00 | 43,397,478.32 | -13,393,378.32 | 144.6 |
| Урамшуулал | | 14,924,442.64 | -14,924,442.64 | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,122,100.00 | 51,884,283.18 | 5,237,816.82 | 90.8 |
| Тэтгэврийн даатгал | 38,843,000.00 | 35,521,104.84 | 3,321,895.16 | 91.5 |
| Тэтгэмжийн даатгал | 4,569,800.00 | 4,178,953.59 | 390,846.41 | 91.5 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,655,800.00 | 3,279,322.66 | 376,477.34 | 89.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 914,000.00 | 809,536.75 | 104,463.25 | 88.6 |
| Эрүүл мэндийн даатгал | 9,139,500.00 | 8,095,365.34 | 1,044,134.66 | 88.6 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 186,775,800.00 | 106,628,988.43 | 80,146,811.57 | 57.0 |
| Гэрэл, цахилгаан | 151,456,900.00 | 79,139,269.55 | 72,317,630.45 | 52.2 |
| Түлш, халаалт | 11,811,100.00 | 4,551,139.35 | 7,259,960.65 | 38.5 |
| Цэвэр, бохир ус | 23,507,800.00 | 22,938,579.53 | 569,220.47 | 97.6 |
| Хангамж, бараа материалын зардал | 20,807,000.00 | 20,558,733.93 | 248,266.07 | 98.8 |
| Бичиг хэрэг | 5,877,300.00 | 5,634,100.00 | 243,200.00 | 95.9 |
| Тээвэр, шатахуун | 5,587,400.00 | 5,587,400.00 | 0.00 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,520,000.00 | 5,515,643.93 | 4,356.07 | 99.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,822,300.00 | 3,821,590.00 | 710.00 | 99.9 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 543,963,800.00 | - | 543,963,800.00 | - |
| Урсгал засвар | 543,963,800.00 | | 543,963,800.00 | - |
| Томилолт, зочны зардал | 12,598,200.00 | 8,339,261.00 | 4,258,939.00 | 66.2 |
| Дотоод албан томилолт | 12,598,200.00 | 8,339,261.00 | 4,258,939.00 | 66.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 579,568,400.00 | 119,323,911.00 | 460,174,589.00 | 20.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 575,034,500.00 | 115,109,580.00 | 459,924,920.00 | 20.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,020,000.00 | 2,020,000.00 | 0.00 | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 619,100.00 | 427,680.00 | 191,420.00 | 69.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 272,900.00 | 269,451.00 | 3,449.00 | 98.7 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 54,800.00 | | 54,800.00 | - |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,048,200.00 | 978,300.00 | 69,900.00 | 93.3 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 518,900.00 | 518,900.00 | 0.00 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 496,800.00 | 493,200.00 | 3,600.00 | 99.3 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 496,800.00 | 493,200.00 | 3,600.00 | 99.3 |

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|--|-------------------------|-----------------------|-----------------------|--------------|
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,344,800.00 | 700,000.00 | 644,800.00 | 52.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,344,800.00 | 700,000.00 | 644,800.00 | 52.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,344,800.00 | 700,000.00 | 644,800.00 | 52.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 465,653,300.00 | 465,653,300.00 | 910,927,500.00 | 100.0 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 465,653,300.00 | 465,653,300.00 | 00.00 | 100.0 |
| Улсын төсвөөс санхүүжих | 465,653,300.00 | 465,653,300.00 | 0.00 | 100.0 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,394,000,000.00 | 483,072,500.00 | 910,927,500.00 | 34.6 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,394,000,000.00 | 483,072,500.00 | 910,927,500.00 | 34.6 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 41 | 39 | 2 | 95.1 |
| Удирдах ажилтан | 7 | 8 | -1 | 114.3 |
| Гүйцэтгэх ажилтан | 31 | 28 | 3 | 90.3 |
| Үйлчлэх ажилтан | 3 | 3 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---------------|--|------------|----------------------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 34,577,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 34,577,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 24,940,135.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,227,058.51 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,215,658.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 572,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 439,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 403,382.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 274,299.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 32,270.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 25,816.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 6,454.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 64,541.17 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 154,310.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 154,310.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 18,725,850.00 |
| 210604 | Урсгал засвар | | 18,725,850.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 2,429,535.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,121,730.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 307,805.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 9,637,364.17 |
| 2131 | Олгосон санхүүжилт шилжүүлэг | | 9,637,364.17 |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт төвлөрүүлэх | | 9,637,364.17 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 34,577,500.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 34,577,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 34,577,500.00 |

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлж, Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах гэсэн зорилготойгоор чөлөөт бүсэд дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, чөлөөт бүсэд газар ашиглуулах, эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохион байгуулна гэсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээр ажиллаж байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хууль, чөлөөт бүсийн тухай хууль зэрэг хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны А/100 дугаар тушаалаар “Чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх журам”
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох”
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол “107 дугаар тогтоолын хавсралт”-д өөрчлөлт оруулах

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллага нь дотоод аудитын ажилтангүй бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамны хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсээс шалгагдагч байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Замын Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцүүлэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Замын Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,675,762.3 мянган төгрөгөөр буюу 7.4 дахин буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|---------------------|---------------------|----------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | |
| Авлага | 47,999.6 | 386.2 | (47,613.4) |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 11,071.8 | 18,236.8 | 7,165.0 |
| Үндсэн хөрөнгө | 38,443,031.0 | 35,807,717.1 | (2,635,314.0) |
| Нийт хөрөнгийн дүн | 38,502,102.4 | 35,826,340.1 | (2,675,762.3) |
| Өглөг | 48,655.8 | 131.2 | (48,524.6) |
| Өмч | 1,350,902.8 | 1,350,902.8 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 37,090,968.4 | 34,463,730.7 | (2,627,237.7) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,575.4 | 11,575.4 | - |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 38,502,102.4 | 35,826,340.1 | (2,675,762.3) |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснуудад гарсан байна. Тухайлбал:

- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь Замын-Үүдийн дулааны станцын зүгшрүүлэлтийн ажлын гүйцэтгэл дууссан тул үлдсэн 47,999.6 мянган төгрөгийг Шадар сайдын албанаас санхүүжилтийг олгохгүй гэж үзэж авлагыг хааснаас;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаар болон байгууллагын дансанд бүртгэлтэй машинаас 3 машиныг балансаас балансад шилжүүлснээс;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь дулааны цахилгаан станцын зүгшрүүлэлттэй холбоотой ажлын Замын-Үүд дулааны станцад шилжүүлэх 47,999.6 мянган төгрөгийн өр төлбөрийг олгохгүй хааснаас;
- Урьдчилж орсон орлого 525.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Тэс Петролиум ХХК-ийн газрын төлбөрийн хөнгөлөгдөх хугацаа дуусаж орлого хүлээн зөвшөөрснөөс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны урсгал санхүүжилтийн эх үүсвэрийг 2,201,289.8 мянган төгрөг, үүнээс улсын төсвийн санхүүжилт 807,289.8 мянган төгрөг, өөрийн орлого 1,394,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг хэвээр батласан байна.

Төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 465,653.3 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны СНАГ-2023/343/НА-СТА-ТШЗ

орлогоос 1,394,000.0 мянган төгрөг нийт 1,859,653.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг улсын төсвөөс нийт 341,636.5 мянган төгрөг буюу 15.6 хувиар бууруулж тодотгосон байна. Үүнд: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 80,214.4 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 261,422.1 мянган төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 465,653.0 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 483,072.5 мянган төгрөг нийт 948,725.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 717,331.8 мянган төгрөгийг зарцуулж, 231,393.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 717,331.8 мянган төгрөг буюу 38.4 хувьтай байгаа нь өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг өмнөх онтой харьцуулахад өндөр төлөвлөсөн боловч эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан орлого тасарсан, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 52,810.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 80,146.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 5,155.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 543,963.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 460,244.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|----------|--|--------------------|------------------|--------------------|-------------|
| 1 | 71201-Чөлөөт бүсийг хөгжүүлэх | 1,859,653.3 | 717,331.8 | 1,142,321.5 | 38.6 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,807,758.5 | 666,081.8 | 1,141,676.7 | 36.8 |
| 1.2 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг | 1,344.8 | 700.0 | 644.8 | 52.1 |
| 1.3 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 50,550.0 | 50,550.0 | - | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 34,577.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,429.6 мянган төгрөг, цалин нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 3,630.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 154.3 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 18,725.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 9,637.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, томилолтын тооцоог зөв бодож олгох, дараа тайланг хугацаанд нь хааж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн аудитор Н.Уранчимэг, аудиторын туслах Д.Должидмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Р.Алтанцэцэг, захирал Г.Энхмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,072,718.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 50,727.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Уг хуулийн хүрээнд тайлант хугацаанд дэд даргыг ажлаас чөлөөлснөөс 725.5 мянган төгрөг, баталсан орон тоо дутуу ажилласнаас 46,847.4 мянган төгрөгийн тус тус цалингийн зардлыг, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахимд шилжүүлснээр 243.2 мянган төгрөг, нийт 47,816.1 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 888,656.6 мянган төгрөгийн 28 мэдээлэл, зарлагын 593,951.9 мянган төгрөгийн 60 мэдээлэл, бусад 67 мэдээлэл, нийт 1,482,608.5 мянган төгрөгийн 155 мэдээллээс 107 мэдээллийг хугацаанд нь, 223,256.4 мянган төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 6-р зүйл 6.4.4-т заасан заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 3 дугаар зүйлийн 3.2.9-т заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах зөвлөмж өгөх.

4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

Тайлант онд дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүй, байгууллагын хөтөлбөр, арга хэмжээний зардалд тусаагүй Замын-Үүд чөлөөт бүсэд шинээр оффисын байр барих зорилгоор зураг төслийн 10,000.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Төсвийн тухай хуулийн төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 171,024.5 мянган төгрөгийн 4 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 171,024.5 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 255,988.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага, 76,821.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-------------------------------|------------------------|------------------|----------|------------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | | 1 | | 100.0 |
| Зөвлөмж | 5 | 76,821.8 | 5 | 76,821.8 | 100.0 |
| Сахилгын хариуцлага тооцуулах | 2 | 255,988.4 | 2 | 255,988.4 | 100.0 |
| Нийт дүн | 8 | 332,810.2 | 3 | 332,810.2 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудалд цалингийн нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодож олгож байгаа эсэх асуудлыг авч үзэх.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,453.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 10,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 453.0 мянган төгрөгийн алдаанд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын хураангуй тайлан, тооллогын үлдэгдлээр 22865 ширхэг 34,124.0 мянган төгрөгийн тасалбарыг зарлагдаж, үлдэгдлийг тоолж санхүүгийн тайланд тусгасан боловч харилцах дансанд тасалбар түгээгч нарын төвлөрүүлсэн орлогын дүн 34,577.0 мянган төгрөг бөгөөд бараа материалын тайланд тусгагдсан тасалбарын үнээс 453.0 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Гэвч шаардах хуудсаар түүвэр хийхэд тасалбар түгээгч нарт 19094 ширхэг 28,371.0 мянган төгрөгийн тасалбарыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.3-т Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ” гэж заасныг мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нярав нь олгосон тасалбарын тоо ширхгийг тасалбар түгээгчид нартай тухай бүр тооцоо нийлж, баталгаажуулан бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж, дотоод хяналтыг сайжруулах.

2. Томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Томилолтыг олгохдоо ирж очих зам хоногийг хасалт хийлгүй тооцож, зарим сарын томилолтыг Сангийн сайдын 120 дугаар тушаалаар баталсан шинэчилсэн тарифаар бодож олгоогүй, томилолтоос ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор дараа тайланг хаагаагүй, илтгэх хуудсыг тайлагнаагүй, хугацаа хэтрүүлж баримт бүрдүүлэн хавсаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Томилолтын дараа тайланг хугацаанд нь хааж, баримтын бүрдлийг хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу томилолтын мөнгийг бодож олгох.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|--------------|---------------|-----|-----------------|-----|----------|--------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тасалбар түгээгчийн харилцах дансанд төвлөрүүлсэн орлого бараа материалын тайлангийн тасалбарын тоо ширхгийн дүнгээс зөрүүтэй байна. | 1 | 453.0 | | | | | 1 | 453.0 | | | | |
| Томилолтын тооцоог буруу бодож олгосон. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 2 | 453.0 | | | | | 2 | 453.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|------------------|---------------|-----|-----------------|-----|----------|------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний зардлын 48 гүйлгээг хугацаа хоцроож сайтад байршуулсан байна. | 1 | 223,256.4 | | | | | 1 | 223,256.4 |
| Дүн | 1 | 223,256.4 | | | | | 1 | 223,256.4 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шинээр оффисын байр барих зорилгоор зураг төсөл зуруулахаар ажил үйлчилгээний зардал гаргасан байна. | 1 | 10,000.0 | | | | | 1 | 10,000.0 |
| Дүн | 1 | 10,000.0 | | | | | 1 | 10,000.0 |
| Нийт дүн | 2 | 233,256.4 | | | | | 1 | 223,256.4 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 2 дугаар сарын 24 № 230/А0150061
СНАГ-2023/343/НА-СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүй, байгууллагын хөтөлбөр, арга хэмжээний зардалд тусаагүй Замын-Үүд чөлөөт бүсэд шинээр оффисын бичир барих зорилгоор зураг төслийн 10,000,000.00 төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Захирагчийн түр орлон гүйцэтгэгч Ц.Ганбат, Захирагчийн ажлын албаны Ерөнхий нягтлан бодогч Г.Ганцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Г.ЭНХМАА

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс